

**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн 2 /хоёр/ жилийн /2017, 2018 он/ санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>2. Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлого санал болгож буй үнийн дүнгийн 100%-иас багагүй байх.</li> <li>3. Татварын өргүй тодорхойлолт ирүүлэх</li> </ol>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:                      Байгууллагын хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо Чингисийн өргөн чөлөө-45, "ЭХХТ" ТӨҮГ өөрийн байр.                      Давхар болон өрөөний дугаар: <b>3 давхар 305 тоот</b></p> <p>Огноо: <b>2019 оны 05 дугаар сарын 10-ны өдөр</b>                      Цаг: 14 цаг 00 минут</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:                      Байгууллагын хаяг: Хан-Уул дүүрэг 3-р хороо Чингисийн өргөн чөлөө-45, "ЭХХТ" ТӨҮГ өөрийн байр.</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 4-р давхарт, Хурлын зааланд                      Огноо: <b>2019 оны 05 дугаар сарын 10-ны өдөр</b>                      Цаг: 14 цаг 30 минут</p>
ТӨӨЗ 3.1 (в)	<ol style="list-style-type: none"> <li>1. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга</li> <li>2. Улсын бүртгэлийн гэрчилгээ, Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлнэ</li> <li>3.Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт, ШШГЕГ-ын тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>4. Гэрээг удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл: Тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай инженер техникийн ажилтнууд, мэргэжилтэн, мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн бэлтгэл, туршлагийг нотлох баримт бичиг баталгаажуулан ирүүлнэ</li> <li>5 Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна.                      Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын <a href="http://www.e-tax.mta.mn">www.e-tax.mta.mn</a> сайтыг ашиглан цахим тодорхойлолт авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь, тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл ирүүлнэ.                      Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын"-ын дагуу "татвар төлөлт, Сангийн яамны санхүүгийн тайлангийн сангаас санхүүгийн тайлангийн шаардлагатай мэдээллийг шалгана".</li> <li>6. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр мэдээлнэ.</li> <li>7. Гадаад хэл дээрх материалыг албан ёсны эрх бүхий орчуулгын төвийн тамга, тэмдэгээр баталгаажсан Монгол хувилбарын хамт ирүүлнэ.</li> <li>8. Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг нотлох баримт бичгийг тендерийн хамт ирүүлнэ.</li> <li>9.Ажлыг гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлэх ба заасан хугацаанд бүрэн дуусган, санхүүжилтийн хуваарийг төсөвт өртөгтэй уялдуулна.</li> <li>10.Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцөлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</li> </ol>
ТӨӨЗ 4.1	<p>Санхүүжилтийн эх үүсвэр нь: Өөрийн хөрөнгөөр                      Төсөвт өртөг: 11,100,000₮</p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хийгдэх ажил: **Серверийн өрөөний тохижилт засварын ажил**

Худалдан авалтын төрөл: **Харьцуулалтын арга**

Төсөв: 11,100,000₮

Серверийн өрөөнд айр кондейшн байрлуулж температурыг тогтмол байлгах

Үүнд:

- SRXCOOL12K загвартай дүйцэхүйц
- Амралтын горимтой өрөөний температурыг тогтмол барьдаг
- Онцгой тохиолдолд хяналтын өрөөнд ослын дохио өгөх
- 220V дээш ажиллах



Серверийн өрөөнд галын дохиолол оруулах, зориулалтын нүүрстөрөгчийн давхар исэлтэй галын хор байрлуулах.

Үүнд:

- 1000в хүртэл хүчдэл бүхий цахилгаан тоног төхөөрөмжид гарсан галыг унтраадаг байх
- Багтаамж 8л-с ихгүй байх
- Бүрээ хошуу
- Нүүрстөрөгчийн хэм -80 градусын хэмд хүрдэг тул биеийн ил, хамгаалалтгүй хэсгийг хөлдөөх аюултай тул мэдээлэл технологийн ажилтан болон байгууллагын жижүүр нарыг галын хортой зөв ажиллах хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтад хамруулж өгөх



Серверийн өрөөнд барилгын үндсэн цахилгааны зангилаа щитнээс шинээр цахилгааны тэжээл

болон газардуулга оруулна. Тоног төхөөрөмжүүдэд газардуулгын холболт хийлгүүлэх.

Шинээр суурилуулсан сүлжээний кабелийн үзүүр бүрд дугаарлалт хийж ойлгомжтой байдлаар барилгын дотоод сүлжээний топологи зураг хийлгүүлэх.

Сүлжээний зургийг серверийн өрөөний хананд байрлуулах.


Үүнд:

- Мэдээлэл технологийн ажилтан байхгүй зарим тохиолдолд хараад ойлгомжтой байдлаар харуулсан
- Үзүүр бүрт дугаарлалт хийж эмх цэгцтэй байлгах

Барилга хооронд татагдсан үндсэн интернетийн шугамыг шаардлагын дагуу шинээр татуулах.

Үүнд:

- Category 6 U/UTP Cable тавих



Серверийн өрөөний усны шугамыг өөр замаар шийдэх, дулааны паарыг авах.